

COOPERATION AGREEMENT	ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ
Feb 01, 2022 Number: NM-A 2322 Bayankhongor province	2022 оны 02 сарын 01 өдөр Дугаар: NM-A 2322 Баянхонгор аймаг
This "Agreement for Mining of Mineral Resources from the Areas with Mining Licenses by Artisanal Mine" (hereinafter referred to as "Agreement") has been made by and between:	Aшигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 4.3 дахь заалтыг удирдлага болгон:
Mr. Khatanbaatar.J, the Governor of the Bayan-Ovoo soum (hereinafter referred to as the "Governor of the Soum") on behalf of the Administration of the Bayan-Ovoo soum of Bayankhongor province (hereinafter referred to as "the Administration of the Soum"), and;	Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Захиргаа (цаашид "Сумын Захиргаа" гэх) Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга (цаашид "Сумын Засаг дарга" гэх) Ж.Хатанбаатар,
Mr. Richard Sawyer, the Country Director on behalf of the " Naran Mandal Enterprises " LLC (hereinafter referred to as "the Company") that holds mining license that has number of MV-006720 at the places named "Ulaan Tolgoi", and	Баян-Овоо сумын Улаан толгой нэртэй газарт ашигт малтмал ашиглах MV-006720 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч "Наран Мандал Энтерпрайзес" ХХК (цаашид "Компани" гэх), түүнийг төлөөлж Улс хариуцсан захирал Ричард Сауэр,
Mr. Otgonchuluun. B, the leader, on behalf of the Tsagaan bogd Partnership /hereinafter referred to as the "Partnership"/, a member of the "Association for Supporting the Individual Artisanal Miners" NGO /hereinafter referred to as the "NGO"/ (detailed information is listed in the Appendix #1), and	"Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо" ТББ /цаашид "ТББ" гэх/-ын гишүүн " Цагаан бодг " Нөхөрлөл (цаашид "Нөхөрлөл" гэх), түүнийг төлөөлж Нөхөрлөлийн ахлах (дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-д жагсаасан) Б. Отгончуулун
Mr. Oyunbold.E, the member of the " Mongolian Artisanal Miners' United Umbrella Association " /hereinafter referred to as the "Association"/ (hereinafter collectively referred to as the "Parties" and individually referred to as a "Party") under following terms and conditions based on mutual negotiations and the clause 42.1 of the Minerals Law and the clause 4.3 of the "Procedure for Mining of Mineral Resources by Artisanal Mine" that was approved by the resolution #296 of the Government of Mongolia in 2022, respectively:	"Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо" /цаашид "Холбоо" гэх/-ны тэргүүлэгч "Э.Оюунболд" нар (цаашид хамтад нь "Талууд", дангаар нь "Тал" гэх) дор дурдсан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү "Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох Гэрээ" (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.
CONDITIONS FOR IMPLEMENTATION OF THE AGREEMENT	ГЭРЭЭ ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ
If following conditions are fulfilled, this Agreement shall enter into force (the Partnership can enter into the Contractual Field):	Дараах нөхцөлүүд хангагдсан тохиолдолд энэхүү Гэрээ хүчин төгөлдөр үйлчилж эхлэнэ (Нөхөрлөлүүд Гэрээт талбайд нэвтэрч болно). Үүнд:
1. The Agreement is signed and confirmed by the Parties. 2. The Partnership has prepared and delivered the documents specified in Clause 2.11 of the Agreement and	1. Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан, 2. Нөхөрлөл нь Гэрээний 2.11-д заасан бичиг баримтыг бүрдүүлж, хүргүүлсэн болон 3-р

<p>1.5. In this Agreement the following terminologies shall have following meaning:</p> <p>1.5.1. "License" means the mining license number MV-006720, which is possessed by "Naran Mandal Enterprises" LLC, and located in the area named "Ulaan Tolgoi" in the territory of Bayan-Ovoo Soum of Bayankhongor province.</p> <p>1.5.2. "Area with Mining License" means the area that was issued under the mining license MV-06720A.</p> <p>1.5.3. "Artisanal Mining Area" means the areas with the certain coordinates and mining depth limits designated temporarily for the purpose of artisanal mining, which are located inside the C and D blocks of the Area with Mining License, specified in the Appendix #2 of this Agreement. These are area that are not economically feasible for mining with industrial methods and which have been formed by utilization and technological waste.</p> <p>1.5.4. "Contractual Hole" means the hole that was permitted under this agreement by the Company for the Partnership in the area where the mineral resources shall be mined by artisanal mining and which has certain radius and depth limits which cannot be exceeded.</p> <p>1.5.5. "Serious Violation" means an action or negligence that has caused (or had potential to cause) damage and losses to human health and life, and/or the properties and business reputation of the Company due to failure of the Partnership, Soum and the Mongolian Artisanal Miners' United Umbrella Association to perform their duties under the Agreement. Repeated violations of the obligations under this Agreement and intentional avoidance from proper fulfillment of them, or action of exceeding the limits of the Contractual Holes specified in this Agreement shall also be considered as the Serious Violations.</p> <p>1.5.6. "NGO" means the "KhAMODKh" NGO,</p> <p>1.5.7. "Association" means the Mongolian Artisanal Miners' United Umbrella Association.</p> <p>1.5.8. "Procedure for Mining of Mineral Resources by Artisanal Mining Methods" means the Procedure for</p>	<p>1.5.1. "Ашиглалтын тусгай зөвшөөрөл" гэж Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт Улаан толгой нэртэй газарт байрлах "Наран Мандал Энтерпрайз" ХХК-ийн эзэмшлийн MV-006720 дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг,</p> <p>1.5.2. "Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай" гэж MV-006720A дугаартай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг,</p> <p>1.5.3. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай" гэж ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас бичил уурхайн зориулалтаар зааж өгсөн солбицлийн цэг, олборлолтын гүний хязгаар бүхий үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон Тусгай зөвшөөрөл бүхий талбайн С, D блокын энэхүү Гэрээний Хавсралт 2-д заасан хэсгийг хэлнэ.</p> <p>1.5.4. "Гэрээт цооног" гэж энэхүү Гэрээгээр Нөхөрлөлийг ажиллуулахаар Компаниас Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай дотор зөвшөөрөл олгосон хэтэрч болохгүй тодорхой радиус, гүний хязгаар бүхий цооногийг хэлнэ.</p> <p>1.5.5. "Ноцтой зөрчил" гэж Нөхөрлөл болон Сум, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс хүний амь нас, эрүүл мэнд, Компанийн эд хөрөнгө, ажил хэргийн нэр хүндэд хохирол учирсан эсхүл учирах нөхцөл байдал үүссэн, эсхүл Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно. Энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн, эсхүл энэхүү Гэрээнд заасан Гэрээт цооногийн хязгаарыг хэтрүүлсэн үйлдлийг мөн Ноцтой зөрчилд тооцно.</p> <p>1.5.6. "ТББ" гэж "ХАМОДХ" ТББ-ыг хэлнэ.</p> <p>1.5.7. "Холбоо" гэж Монголын Бичил уурхайн Нэгдсэн дээвэр холбоог хэлнэ.</p> <p>1.5.8. "Бичил Уурхайгаар Ашигт Малтмал Олборлох Журам" гэж Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор батлагдсан</p>
--	--

<p>13.1.6. The Company went bankrupt and Company's operations were forcibly stopped by the administrative order and decision of the relevant authorities,</p> <p>13.1.7. Certain parts of the areas of the license have been taken for special uses by the administration organization. In this case, the Governor of the Soum and the Administration of the Soum shall be liable for compensation of any loss incurred due to the respective action,</p> <p>13.1.8. The Parties mutually agree to prematurely terminate the Agreement.</p> <p>13.1.9. This Agreement is made based on the Memorandum of Understanding signed with the NGO on Feb-01, 2021. The Parties understand and agree that the activities of the other member partnerships of the NGO and violations of the agreement shall affect this Agreement. Therefore, the Company has the right to unilaterally terminate this Agreement, if the member partnerships of the NGO do not release the fields in the Middle Rocks or D block of the License Area within June 25, 2023.</p> <p>13.1.10. Any other basis specified in the laws and this Agreement.</p> <p>13.2. In the event that the Partnership or the Governor of the Soum fails to fulfill their obligations under this Agreement, fails to fulfill them properly, or repeatedly violates or commits a Serious Violation, if the continuation of the Agreement, regardless of whether the respective violation has been eliminated or the losses and damages incurred by the Company have been fully compensated, is contrary to the rights and legal interests of the Company, the Company has the right to terminate this Agreement unilaterally.</p> <p>13.3. In the event that the Company or the Governor of the Soum fails to fulfill their obligations under this Agreement, fails to fulfill them properly, or repeatedly violates or commits a Serious Violation, if the continuation of the Agreement is contrary to the rights and legal interests of the Partnership, the Partnership has the right to terminate this Agreement unilaterally.</p> <p>13.4. In the event that the Partnership or the Company fails to fulfill their obligations</p>	<p>13.1.7. Тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг захиргааны байгууллагаас тусгай хэрэгцээнд авсан. Энэ тохиолдолд Сумын Засаг дарга ба Сумын Захиргаа нь тухайн үйл ажиллагааны улмаас учирсан аливаа хохирлыг нөхөн төлөх хариуцлага хүлээнэ,</p> <p>13.1.8. Талууд харилцан тохиролцож энэ Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан,</p> <p>13.1.9. Энэхүү Гэрээ нь ТББ-тай 2021 оны 02 сарын 01-ний өдөр байгуулсан Харилцан ойлгоцлын санамж бичгийн үндсэн дээр байгуулагдаж байгаа бөгөөд ТББ-ын гишүүн бусад нөхөрлөлийн үйл ажиллагаа, гэрээний зөрчил нь энэхүү Гэрээнд нөлөөлөхийг Талууд ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа. Иймд ТББ-ийн гишүүн нөхөрлөлүүд Дунд чулууны буюу Тусгай зөвшөөрлийн D блок дахь талбайг 2023 оны 6-р сарын 25-ны дотор чөлөөлөгүй тохиолдолд Компани энэхүү Гэрээг дангаар цуцлах эрхтэй.</p> <p>13.1.10. Хууль болон энэ Гэрээнд заасан бусад үндэслэл.</p> <p>13.2. Нөхөрлөл эсхүл Сумын Засаг дарга энэ Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй буюу удаа дараалан зөрчсөн эсхүл Ноцтой зөрчил гаргасан тохиолдолд тухайн зөрчлийг арилгасан эсэх, Компанид учирсан хохирлыг бүрэн төлж барагдуулсан эсэхээс үл хамааран Гэрээг цааш үргэлжлүүлэх нь Компанийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол Компани энэ Гэрээг дангаар цуцлах эрхтэй.</p> <p>13.3. Компани эсхүл Сумын Засаг дарга энэ Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй, удаа дараалан зөрчсөн эсхүл Ноцтой зөрчил гаргасан бөгөөд Гэрээг цааш үргэлжлүүлэх нь Нөхөрлөлийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд харшлахаар бол Нөхөрлөл энэ Гэрээг дангаар цуцлах эхтэй.</p> <p>13.4. Нөхөрлөл эсхүл Компани нь энэ Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй, удаа дараалан зөрчсөн эсхүл Ноцтой зөрчил гаргасан бөгөөд Гэрээг цааш үргэлжлүүлэх нь Сумын Засаг даргын эрх, хууль ёсны ашиг сонирхол (нийтийн ашиг сонирхол)-д сөргөөр нөлөөлөхөөр бол Сумын Засаг дарга энэ Гэрээг дангаар цуцлах эрхтэй.</p> <p>13.5. Гэрээг цуцлах үндэслэл үүссэн тохиолдолд, Гэрээг цуцалж байгаа Тал нь Гэрээг цуцлах тухай мэдэгдлээ бусад Талууддаа илгээнэ. Хэрэв Гэрээг зөрчсөн тал хуанлийн 3 өдрийн</p>
---	--

obligation to clear any breach or the cancellation of this Agreement, repeated breach of the Agreement, and not adhering to the respective clauses.	тухайн заалтыг дагаж мөрдөхгүй байх үндэслэл болохгүй.
16.5. No Party shall assign to any third persons the rights, obligations and interests under this Agreement without a prior written consent of the other Parties.	16.5. Аль нэг Тал нөгөө Талуудаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
16.6. This Agreement shall be executed in English and Mongolian languages. If any conflict or contradiction arises between translated versions of the Agreement, the English version shall prevail.	16.6. Энэхүү Гэрээ нь Англи, Монгол хэлээр үйлдэгдэнэ. Гэрээний орчуулгын хувилбарууд хоорондоо зөрчилдөх буюу зөрүүтэй тохиолдолд англи хэл дээрх хувилбар нь давамгайлна.
16.7. If any clause(s) or stipulation(s) of this Agreement is/are found to be in violation or contradiction of Mongolian laws, the remainder of the Agreement shall still remain valid and the clause(s) in question shall be re-written to conform with the laws while retaining the spirit of the original clause to the greatest extent possible.	16.7. Хэрэв энэхүү Гэрээний аливаа зүйл, заалтууд нь Монгол Улсын хуульд нийцээгүй, зөрчилтэй гэж үзвэл Гэрээний үлдсэн хэсэг нь хүчин төгөлдөр хэвээр үлдэх бөгөөд зөрчилтэй тухайн зүйл, заалтуудын үндсэн утга санааг хамгийн боломжтой байдлаар хадгалан үлдэх байдлаар хуульд нийцуулэн дахин бичнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД/THIS AGREEMENT HAS BEEN MADE BY AND
BETWEEN:**

THE GOVERNOR OF THE BAYAN-OVOO SOUM

...../KHATANBAATAR J/
The Governor of the Bayan-Ovoo soum
Address: Bayankhangor province, Governor's office of the Bayan-Ovoo soum
Phone: 88082480, 99922244

БАЯНОВОО СҮМҮН ЗАСАГ ДАРГА

...../Ж.ХАТАНБААТАР/
Баян-Овоо сумын Засаг дарга
Хаяг: Баянхонгор аймаг, Баян-Овоо сум ЗДТГ
Утас: 88082480, 99922244

NARAN MANDAL ENTERPRISES LLC

...../RICHARD SAWYER/
Country Director
Address: Ulaanbaatar city, Olympic street-5, Sukhbaatar district, 1st khoroo, Ayud tower, Suite# 605-606
Phone: 7777-3232

НАРАН МАНДАЛ ЭНТЕРПРАЙЗЕС ХХК

...../РИЧАРД САУЭР/
Улс Хариуцсан Захирал
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп гудамж-5, Аюуд тауэр, 605-606 тоот
Утас: 7777-3232

PARTNERSHIP

...../Багасан Бодж...../НӨХӨРЛӨЛ
...../Б.Огтогчилтуун...../Б.Огтогчилтуун/

Leader of the Partnership
Address: Bayankhongor soum, 1st bagh, Building #54,
door #UU-13
Phone:

**THE PROFESSIONAL UNITED UMBRELLA
ASSOCIATION OF THE MICRO MINES**

Head of the Association
Address: UB city, Bayanzurkh district, 1st khoroo, Tokyo
Street, Plasso tower, Suite #102
Phone: 91111632

/OUYNBOLD.E/

Нэхөрлөлийн ахлах
Хаяг: Баянхонгор сум, 1-р баг, 54-р байр, YY-13 тоот
Утас: **8844 9966**

БИЧИЛ УУРХАЙН НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО

Монголын
БИЧИЛ УУРХАЙН
НЭГДСЭН ДЭЭВЭР
ХОЛБОО
/Э.Оюунболд/
Холбооны Тэртүүн
Хаяг: Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Токиогийн гудамж,
Плаззо таузэр, 102 тоот
Утас: 91111632